



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2023 оны 08 сарын 03 өдөр

Дугаар A/59

Улаанбаатар хот

**Шагнах тухай**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шагналын журам"-ын 3.4, 3.6, 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Монгол Улсад Төмөр замын тээвэр үүсэж хөгжсөний 85 жилийн ойн баярыг тохиолдуулан "Монголын төмөр зам" төрийн өмчит хувьцаат компанийн Цогтцэций өртөөний диспетчер инженер Доржсүрэн овогтой Буянбатыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын "Өргөмжлөл"-өөр, мөн тус компанид идэвх зүтгэл, үр бүтээл гарган ажиллаж байгаа Захиргаа, удирдлагын газрын ахлах мэргэжилтэн Хувьт овогтой Эрдэнэбаярыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын "Хүндэт жуух бичиг"-ээр тус тус шагнасугай.

2.Шагналд дагалдах 100,000 (нэг зуун мянган) төгрөгийг зохих журмын дагуу олгохыг холбогдох байгууллагын удирдлагуудад зөвлөсүгэй.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

132013639